

Ч. Дашдаваагийн “Японы олзлогдогсод Монголд” номын шүүмж

Л.В. Курас, Б.Д. Цыбенков¹

Монголын нэрт түүхч профессор Ч.Дашдаваа нь Дэлхийн хоёрдугаар дайны дараа Монгол руу явуулсан японы олзлогдогсдын талаархи судалгааны бүтээлээрээ танигдсан хүн юм. Хэдийгээр энэхүү сэдэв нь их чухал судлагдах сэдэв боловч дэлхийн дорно дахин судлалд одоог хүртэл тийм ч тодорхой судалж үзээгүй байна. Ихэвчлэн Ч.Лувсан-Очир (1998), Э.Лувсанбалдан (2001), Ж.Дашдаваа (2007), Сийлэгмаа (2011) болон хуучин японы олзлогдогсдын цэргүүд байсан Нобор Х. (1991), Какихэ К. (1994), Канерсиру Т. (2009) зэрэг хүмүүсийн шийдэлд хүрээгүй асуудлуудыг судалж буй ганц нэг олон нийтэд зориулсан шинжлэх ухааны хялбарчилсан бүтээлүүд (өгүүллүүд, дурсамжууд) байдаг байна. Ч. Дашдаваагийн судалгааны ажилд энэхүү чухал судалгааны ажлуудаас гадна монголын эрдэмтэн Ц.Батбаяр, оросын С.В.Карасева, Е.Л. Катасонова зэрэг судлаачдын бүтээлийн эх үүсвэр нь Ч.Дашдаваагийн судалгааны ажлын чухал баримт болсон байна. Тус нэг сэдэвт зохиолын чухал эх сурвалж нь Монголын Үндэсний түүхийн архив болон бусад монголын архив, үүнээс гадна бичгийн эх үүсвэрүүд, баримтат кино-зургийн баримт болсон байна. Судлаач уг судалгааны ажлаараа Япон руу явсан ба

¹ КУРАС Леонид Владимирович – түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд, Будда судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх зэргийн ажилтан. E-mail: kuraslv@yandex.ru
ЦЫБЕНОВ Базар Догсонович – доктор (Ph.D), ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд, Будда судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан. E-mail: bazar75@mail.ru

ОЛОН УЛС СУДЛАЛ

шинжлэх ухааны хоёр бага хуралд илтгэл тавьсан байна (2012 оны 04 сарын 14-нд Сэйкэй их сургууль, 2012 оны 05 сарын 25-нд Тохоку их сургууль).

Судалгааны эхэн хэсэгт Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийн үе шат багахан хэмжээгээр судалсан болно. Энд гол анхаарах зүйл нь Крымын бага хурлын БНМАУ-ын бие даасан байдлыг тунхагласан тунхаг бичиг ба мөн И.Сталин болон Х.Чойбалсан нарын 1945 оны Москва дахь уулзалт, японы империализмийн эсрэг тулалдсан Орос-Монголын чөлөөлөх армийн эцсийн үр дүнгийн тухай илүү анхаарал хандуулсан байна. Орос-Монголын судлаач эрдэмтдийн хамтран эмхтгэсэн шинжлэх ухааны эмхтгэл болох “Халхын голоос Миссури хөлөг онгоц хүртлэх” бүтээлийг ашигласан ба уг бүтээлд илүү тодорхой судалгаанууд орсон болно. Цаашлаад ЗХУ-ын газар нутаг дээрхи японы олзлогдогсдын талаархи тоо бүртгэлийн мэдээллийг нэг бүрчлэн судалсан байна. Судлаач статистик тоо баримтаас илүүтэй Монгол руу явуулсан японы олзлогдогсдын талаархи асуудал дээр анхаарч үзсэн байна. Түүхийн архивыг нягтлан судалж үзсэнээр, Монголын Засгийн газар 1945 оны 08 дугаар сарын сүүлээр японы олзлогдогсдыг хүлээж авах талаар мэдсэн төдийгүй бэлтгэлтэй байжээ гэсэн дүгнэлтэд судлаач хүржээ. Баримт бичгээс үндэслээд харахад, 1945 оны 08 дугаар сарын 31-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн хурлаар японы олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газрыг зохион байгуулах шийдвэр гаргажээ. 1945 оны 09 сарын 04-ны өдөр анх Монгол руу олзлогдогсдыг илгээх талаархи асуудал сөхөгдсөн гэдгийг С.В.Карасевийн нийтлэлээс судлаач дүгнэн гаргасан байна. Дашдаваа нь Монголд ирсэн олзлогдогсдын тоо хэмжээ тодорхой бусаар янз бүрээр бичигдсэн байдаг гэж үзжээ. Төмөр замын Наушк станц дээр 20 мянган хүн ирнэ гэж үзсэн байхад өөр баримт дээр 18010 хүн, Р.Рупены мэдээллээр Монголд 15000 хүн харин С.В.Карасевын тооцоогоор 12318 японы олзлогдогсод байх ёстой байж. 1945 оны 11 дүгээр сараас 12 дугаар сарын хооронд япончуудыг монгол-оросын төмөр замаар дамжуулан шилжүүлж байхад, Монгол Улсад 20 мянган хүнийг байршуулах байр, хооллох хүнс тэжээлийг бэлтгэх хүнд даваа тулгарчээ. Тийм учраас 7 мянга орчим олзлогдогсдыг Сибир ба Алс Дорнод руу явуулсан хэмээн үзэж байна. Отрядын дарга хошууч

НОМЫН ШҮҮМЖ

Е.Нанзаддоржийн дурсамжаас үзэхэд, дайны шарх болон, даарч зутран өвдсөнөөс (тэд бараг зуны хувцастай байсан тул) олзлогдогсдын тоо багасч байсан ба, тэднийг 30, 40-өөр нь групп болгон бусад лагерьт шилжүүлэн ачдаг байжээ. 1945 оны 11 сарын 20-нд Наушк өртөөнөөс явганаар анхны групп 4956 олзлогдогсод Сүхбаатар хот руу иржээ. Дараагийн 5 групп хүмүүс автомашинаар Наушк өртөөнөөс Хиагт болон Алтанбулагаар дайраад 11 сарын 23-нд Сүхбаатарт 1404 хүн, 12 сарын 04-нд гурав дахь хэсэг болох 1479 хүн, 12 сарын 05-нд дөрөв дэхь хэсэг болох 1494 хүн; 12 сарын 09-нд тав дахь хэсэг болох 1497 хүн, 12 сарын 10-нд 6 дахь хэсэг болох 1458 хүн тус тус иржээ. Бидний үзэж байгаагаар нийтдээ 12288 хүн, ерөнхий бүртгэлээр 12318 олзлогдогсод ирсэн гэсэн зөрүүтэй тоо гарч байна. Японы нэгэн цэргийн дурсан хэлснээр хуруу, гараа тайруулсны дараахи үе хамгийн хүнд байсан хэмээн хэлжээ. Монголд ирж байсан японы олзлогдогсдоос маш их хүмүүс шархтай байсан тул Сүхбаатар хотод цэргийн эмнэлэгийн газар ба япон өвчтөнүүдийг эмчлэх газар их өргөн хүрээнд байгуулсан байна. Олзлогдогсод дунд хоёр эмэгтэй байсан ба нэг эмэгтэй нь нөхрийнхөө хамт эмнэлэгт ажиллаж байгаад Япон руугаа амьд мэнд буцсан байна. 1990-ээд оны сүүлээр монголын профессор Д.Цэдэв Токио дахь их сургуульд ажлаар явж байхдаа энэхүү гэр бүлийн эмэгтэйтэй уулзсан ба харин нөгөө эмэгтэйн хувь заяа огт тодорхойгүй бөгөөд архивын материалд түүний талаар дурьдаагүй байна. Ч.Дашдаваагийн үзэж буйгаар олзлогдогсдын ихэнхи нь Сүхбаатар аймгийн түүхийн эдийн бааз болон Алтанбулагийн арьс ширний үйлдвэр, мөн Сэлэнгэ аймгийн нилээд хэдэн хүн ам төвлөрсөн газруудад хуваарилагдан үлдсэн байна. Бусад үлдсэн олзлогдогсдыг Улаанбаатар хот руу машинаар зөөвөрлөн авчиржээ. Олзлогдогсдын лагерийн захиргаа тэднийг хүлээн аваад ямар мэргэжлээр ажиллаж чадах талаар судалгаа гаргажээ. Жишээ нь 1071 хүнээс 45 төрлийн мэргэжилтэн, үүнээс жолооч болон засварчин – 195 хүн; аж үйлдвэрийн техникч, засварчин – 173 хүн; нягтлан – 107; барилгын мод бэлтгэгч, талхчин, чихэр боовны мэргэжилтэн – 67 хүн; радиогийн техникч – 61; цахилгаанчин – 50 хүн; төмрийн дархан – 38 хүн; барилгын инженер – 32; эм зүйч – 21; ногоочин – 21 хүн; галт тэрэгний машинч – 18 хүн; эмч – 17 хүн; токарьчин – 16; оёдолчин – 13 хүн; төмөр ба звасмал замын зураг хийдэг хүн – 12 хүн; хиамчин

– 10; гуталчин – 8 хүн; гагнуурчин – 7 хүн; мал эмнэлэгийн бага эмч – 8 хүн; эрүүл ахуйч – 7 хүн; зурагчин – 6 хүн; төмөр замчин – 6 хүн; цагчин – 6 хүн; шавар, ваар урлаач – 5 хүмүүс байжээ. Мөн шүдний эмч, үсчин, холбоочин, ширэм цутгагч, хөлөг онгоцны засварчин, хөвөн үйлдвэрлэгч гэх мэт олон мэргэжилтэн байсныг бичсэн байна. Хэдийгээр ганц хэсгийн тухай бичсэн боловч Монголд байрлаж байсан бүх олзлогдогсдыг энд тоочиж бичих боломжгүй байсан. Ч.Дашдаваагийн тооцож буйгаар нийт олзлогдогсдын 10% орчим буюу 1000-аас илүү хүн энгийн иргэн байжээ. Судлаачийн үзсэнээр 1947 оны 10 дугаар сард зөвлөлт засаг 1188 хүн Япон руу илгээжээ. Энэ тоо баримт 1143 энгийн иргэд япон руу буцсан С.В.Карасевын тоо баримттай ойролцоо байна. Гэвч энэ бага боловч тооны зөрүү нь тодорхой, нарийн судалгааг шаардаж байна. Судлаачийн үзэж буйгаар Халхын голын хөндий, Жанчхүү уулын бэлд Монголд олзлогдсон японы цэргүүд болон энгийн иргэдийг Зүүн-Хойд Хятадын хэсэгт Харчины газар нутаг дээр болж байсан дайны газар нутаг руу шилжүүлжээ. Бидний тооцооллоор энэхүү асуудлыг японы архивын материалтай хавсарган хянаж үзвээс бүрэн судлагдаагүй асуудлын зарим хариултыг олж болох юм. Мөн маш олон тооны цэрэгтэй Квантуны арми Манж-Го улсыг байгуулсан боловч энэ нь хэдхэн хоногын хугацаанд оршин тогтносныг энд тэмдэглэж хэлэх ёстой (1, ху 28-30).

1945 оны 10 сарын 12-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөр баталгаажуулсан японы олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх газар, мөн түүний үйл ажиллагааг нарийвчлан судалсаны дүнд зохион байгуулалтын өөрчлөлт хийж бүх тоног төхөөрөмжийг олзлогдсон хүмүүсийг хянах хэлтэс, түүний зохион байгуулалтын хамт Дотоод Явдлын Яамны үйлдвэрлэлийн хэсэг болгон өөрчилжээ. 1947 оны 11 сарын 04-нд японы олзлогдогсод ЗХУ, Япон руу буцахад японы олзлогдогсдын хэрэг эрхлэх газрыг барилгын хэрэг эрхлэх газар болгон өөрчилжээ. Ч.Дашдаваа нь японы олзлогдогсдын хэрэг эрхлэх газрын бүтэц, үйл ажиллагаа зөвлөлтийн зөвлөхүүд болон олзлогдогсдын ажлын хөлс, лагерын эд хөрөнгө, эмнэлэг, санхүү, прокурорын мөрдөн байцаах хэсэг зэрэг тухайн үеийн аж ахуй, үйл ажиллагааны байдлыг судалж үзсэн байна. Судлаачийн үзэж буйгаар, удирдах ажил хийж байсан хүмүүсийн байдлаас болон, дээд удирдлагын буруу шийдвэр,

НОМЫН ШҮҮМЖ

хараат байдлаас болж алдаа гарч байжээ. Уг бүтээлд судлаач японы олзлогдогсдыг байрлуулж байсан 37 лагерийн талаар дэлгэрэнгүй авч үзсэн ба олзлогдогсдын ихэнхи хэсэг нь Улаанбаатар хотын төв хэсэгт 839 хүн, 5-аар үйлдвэр дээр 1409 хүн, 1-ээр колони дээр 940 хүн, Цагаан хуаранд 648 хүн тус тус байрлуулснаас гадна Сүхбаатар аймагт 500 хүн, мөн Алтанбулагт 300 хүн хуваарилагдсан байна. Архивын баримтаас үзэхэд Монголд байсан Японы олзлогдогсдод хоол, хувцас, эмийн хангамж, байрлах газар хүрэлцдэггүй байснаас гадна ихэнхи олзлогдогсдод дэвсгэр хөнжил байдаггүй байсан ба зарим олзлогдогсод Амгалан, Хужирбулан, 1-ээр колоний орчим газар доор нүх ухан амьдарч, маш хүнд нөхцөлд байжээ. Хэдийгээр Монголд олзлогдогсдод стандарт хэмжээгээр өдөрт 300 грамм ногоо, 400 грамм будаа, 60 грамм мах өгдөг байсан боловч хүнсний хангамж маш муу байв. Хуучин Японы цэргийн дурсамжаас үзэхэд, олзлогдогсод аль лагерьт байрлаж байснаас шалтаалж хүнсний хангамж өөр өөр байсан ба хар талх, усанд найруулсан будааны зутан, зарим лагерьт амралтын өдрүүдээр монгол бяслаг 2 ширхэг жигнэмэг, гахайн мах, үхрийн мах өгдөг байсан байна. Хүнстэй холбоотой хулгайн гэмт хэргүүд болон бусад хэргүүд лагериудад их болдог байжээ. Олзлогдогсдыг өвөл, зуны хувцсаар хангаж байсан судалгааны баримт хангалттай байхаас гадна Ч.Дашдаваад 1946-1947 оны хооронд олзлогдогсдыг өвлийн хувцсаар сайтар хангаж өгч байсан талаархи баримт, материал олдсон байна. Гэвч баримтаас үзэхэд 1946 оны 12 сарын 19-нд 106 олзлогдогсод бээлийгүй, 205 олзлогдогсод даавуун өмдгүй, ихэнхи олзлогдогсдод хуучирсан эсгийн гутал өмсүүлж “Шүдэнзний үйлдвэр”, мөн түүнээс 6 км-ийн зайтай газарт, дээрхи барилгад ашиглагдах чулуу, элсийг олборлож байжээ. Ч.Дашдаваа нь, лагерийн захиргаа олзлогдогсдыг хувцас, хүнсээр хангах талаар илүүтэй анхаарч байсны улмаас соёлын үйл ажиллагаа ерөнхийдөө орхигдож байсныг тэмдэглэж хэлсэн байна. Зарим үед лагерь дээр олзлогдогсдод соёлын арга хэмжээний үеэр кино үзүүлдэг байсан нь олзлогдсон Япончуудыг хариуцах газраас ирсэн тушаалын дагуу кино архивт хадгалагдаж байгаа кинонууд болох “Япончуудын үг дуугүй бууж өгөх тухай актад гарын үсэг зурсан”, “Германчууд бууж өгөх тухай актад гарын үсэг зурсан”, “Курско-Орлевын тойрог дахь байлдаанд фашистуудыг

ОЛОН УЛС СУДЛАЛ

бут ниргэсэн нь”, “Сталинградын тулалдаан”, “Монгол” гэх зэрэг баримтат кинонуудыг үзүүлдэг байв. С.В.Карасевын бичсэнээр, японы коммунистуудыг олзолсон 39 лагерийн үйл ажиллагаатай Улаанбаатарыг адилтган дүгнэснийг судлаач үгүйсгэн, хэдий байдал хүнд байсан боловч олзлогдогсод үзэл сурталын ухуулга хийж байгаагүй хэмээн үзсэн байна. Бидний үзэж буйгаар Ч.Дашдаваагийн зөв байсан ба Улаанбаатарыг Магадан эсвэл Иркутскт явуулж байсан үйл ажиллагаатай харьцууламгүй юм. Монголын Үндэсний түүхийн архиваас судлаачын үзсэнээр, аж үйлдвэрийн комбинат болон артельд – оёдолчин, гуталчин, мод бэлтгэгч зэрэг аж ахуйн ажилтан, Налайхын уурхай, арьс ширний үйлдвэр, Цэргийн яамны барилгын газар, хүнсний комбинат, гүүрийн барилгын ажил, зам засвар, хотын барилгын удирдах хэсэг гэх мэт, мөн бусад газруудад японы олзлогдогсдыг хүнд хөдөлмөр эрхлүүлж байжээ. Цөөн хэсэг нь жолооч, ачигч, машины засварчин, ногоочин мөн загасчнаар ажиллаж байв. Мөн Улаанбаатар хотыг тохижуулах ажилд олон олзлогдогсдыг үйлдвэрийн тоосго цохих, хотын барилгын объектын чулуу, элсний материал, барилгын шат угсрах зэрэг ажлуудад дайчилдаг байжээ. Сүхбаатарын төв талбайн хажууд болон Засгийн газрын ордон, Улсын их театр, их сургууль, гадаад явдлын яам, кинотеатр, зочид буудлыг барьж, Сүхбаатарын хөшөөны суурийг тавьж, нийтдээ 30-аас илүү томоохон бүтээн байгуулалт босгосон байна. Өнөөдрийн Улаанбаатарын дүр төрх нь японы олзлогдогсдын хөдөлмөрийн нэг хэсэг тул тэдний хувь нэмэрийг үнэлэхгүй байхын аргагүй юм хэмээн судлаач тэмдэглэсэн байна.

Мөн олзлогдогсод оргох асуудал нь тэдний эсэргүүцлээ илэрхийлэх нэг алхам болдог байсан ба энэ нь монголын лагерийн ажилтнуудад хүндрэл учруулдаг байжээ. Жишээ нь, 1946 оны хавар, оргох оролдлого хийсэн хүний тоо 75-д хүржээ. Зөвхөн зугтах асуудал нь тэднийг шийтгэх шалтгаан байсангүй, дээрэм, ажил хаялт, машин бүтээхэд гаргах алдаа зэрэг нь гол шалтгаануудын нэг хэсэг нь байсан юм. Хэзээ суллагдах хугацаагаа мэдэхгүй, мөн эмнэлэгийн хүрэлцээ хангалтгүй байсан зэрэг нөхцлүүд японы олзлогдогсод маш хүнд тусч байжээ. Газар доор, нүхэнд амьдарч байсан олзлогдогсод бага калортай хүнс хэрэглэж байснаас үүдэн хижиг, сүрьеэ, улаан суулга зэрэг өвчин

НОМЫН ШҮҮМЖ

тэдний дунд газар авч байв. Нийт 12318 хүний 1615 буюу 13,1% нь монголын газар нутаг дээр нас барьсан байна. Ч.Дашдаваагийн үзэж буйгаар Монголд 1945 оны 12-р сар, 1946 оны 1-2-р саруудад нийт олзлогдогсдын 34,2% (1/3 нь), эхний ирсэн гурван сарын хугацаанд, зөвлөлтийн лагерт байсан олзлогдогсдоос илүү их олзлогдогсод нас барсан байна гэжээ. 1946 оны 3-р сард нийт үхэгдэгсдийн тоо 553-д хүрсэн ба үхлийн гол шалтгаан нь уушигны сүрьеэ, уушигны үрэвсэл, цусан суулга, сульдаа, хижиг, шар өвчин, зүрхний өвчин зэрэг өвчнүүд нь үхлийн шалтгаан болж байв.

1947 оны намар буюу 10-р сарын 14-17-нд Зөвлөлтийн талаас олзлогдогсдыг буцаах үйл ажиллагааг эхлүүлж нийт 10705 хүнийг 20 хоногийн хоол хүнс, дулаан хувцсаар ханган эх оронд нь суллаж явуулжээ. Монгол дахь японы олзлогдогсдыг суллах ажлыг хариуцсан комиссын нарийн бичгийн дарга М.Мягмаржавын дурсамжаар “Бүх олзлогдогсдод 2-3 ширхэг тэмдэглэл хөтөлсөн дэвтэр байсан ба энэхүү дэвтэрт Монголд өнгөрүүлсэн цаг хугацаагаа, болж байсан үйл явдлаа бичиж байсан байна. Монголчууд аюулгүй байдлаа бодож бүх дэвтрийг шатаасан ба энэ нь маш том алдаа байсан юм” (273 ху). Япончуудыг Монголд оршуулсан асуудлын талаар монголчууд япончуудтай 1970-2000 оны хооронд илүү ил тод, найрсаг байдлаар харилцаж байжээ.

Ч.Дашдаваагийн бүтээлийг сайн судалгаа болсон гэж үзсэн боловч, бидний олж харснаар, жишээ нь судлаач С.Товуудоржийн нэр өөр хэсэг дээр С.Товруудорж гэж бичигдсэн, мөн 135-р хуудас дээр 1945 оны 11-ээр сарын 16-нд үйлдвэрийн комбинатад японы 618 олзлогдогсод ажиллаж байсан гэж бичсэн байхад 1945 оны 11-ээр сарын 20-нд Монголд анхны японы олзлогдогсод ирсэн хэмээн судлаач бичсэн зэрэг техникийн алдаанууд харагдаж байна. Магадгүй эртний баримтаас янзалж, салгаж авсан зураг бүхий хар-цагаан баримтуудын чанарын төвшин муу байсан байж болох юм. Мөн уг бүтээлд зарим С.В.Карасевийн “Монголд олзлогдсон японы цэргүүдийн асуудал” (1945-1947 он), “Орос ба Дорноос: Шинэ мянганыг Сибирээс харах нь” (Эрхүү: Отгиск, 2002. 36-38 ху), “Хоре тайкэн ни” найман боть ном (олзлогдогсдын дурсамж) зэрэг нь ороогүй байна. С.И.Кузнецовын энэ асуудлын тухай Орос, Японд хэвлэгдсэн “Японы олзлогдогсод Сибирт

(1945-1956 он)” (Эрхүү, 1997 он), “Япончуудын эрх чөлөө ЗХУ-д (1945-1956 он) зөвлөлт болон оросын түүхийн шинжлэх ухаанд”, “Зүүн-хойд Ази дахь Сибир ба Япон: 2002 оны 9 сарын 8-ны Эрхүү дахь орос-японы бага хурлын материал (Эрхүү: Оттиск, 2003. 16-23 ху)”, “The situation of Japanese Prisoners of War in Soviet Camps”// The Journal of Slavic Military Studies. (London: Frank Cass, 1995-Vol.8. N3. P. 612-630), “Сибэриа-но нихондзин хорётати. (Японы олзлогдогсод Сибирт)”, (Токио: Сюэйся. 1999) болон буряд судлаач О.Д.Базаровагийн “Сибир дэхь эрх чөлөөний ажиллагаа: японы олзлогдогсод Буриадад (1945-1948 он)” (Улаан-Үд, 1997). Нөгөө талаар, судлаач С.В.Карасевын бичсэн Монгол дахь олзлогдогсдын талаарх бүтээлийг мэргэжлийн төвшинд шүүмжилсэн ба, харин энэ явцдаа техникийн бага зэрэг алдаануудыг гаргасан нь бидэнд ажиглагдсан юм. Бидний үзэж буйгаар, архивын материал дээр үндэслэгдэн бичигдсэн, түүхэн баримтат дурсамжаас иш татсан энэхүү Ч.Дашдаваагийн “Японы олзлогдогсод Монголд” хэмээх бүтээл нь дайны дараах Монгол ба Японы хоорондын түүхийн цоорхойг нөхөж, монгол судлаач, япон судлаач, түүхчдэд шинжлэх ухааны судалгаа хийхэд, хувь нэмэр болохуйц бүтээл болсон хэмээн үзэж байна.

Орчуулсан Э.Сувд

НОМ ЗҮЙ

1. Базаров Б.В. Генерал-лейтенант Маньчжоу-Го Уржин Гармаев. Улан-Удэ: изд-во БНЦ СО РАН, 2001. 37 с.
2. Карасев С.В. История плена: советско-японская война и ее последствия (1945-1956 он): автореферат диссертации на соискание ученой степени доктора исторических наук. Улан-Удэ, 2007. С.38.
3. Курас Л.В. Вторая мировая война и Монголия: современная российско-монгольская историография // Ученые записки Забайкальского государственного гуманитарно-педагогического университета имени Н.Г. Чернышевского. 2013. Номер 46-2. С. 124-131.
4. От Халхин-Гола до линкора Миссури: сб. Науч. Ст. / науч. Ред.: Ч.Дашдаваа, Л.В.Курас. Улан-Удэ; Улан-Батор: изд-полигр. Комплекс ФГОУ ВПО ВСГАКИ, 2010. 141 с.